



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

УЛААНБААТАР ДУЛААНЫ СҮЛЖЭЭ ТӨХК-ИЙН 2021 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/97/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Улаанбаатар хот
2022 он

Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Ц.Хосжаргал
Утас: 261885
Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn
Аудитор: С.Бат-Эрдэнэ
Утас: 261740 Цахим хаяг: bat-erdenes@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Бизкон Аудит" ХХК
Захирал: Л.Отгонбаяр
Утас: 312773 Цахим хаяг: info@bizcon.mn

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	9
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	11
4. Санхүүгийн тайлангийн тодруулга	11
4.1 Байгууллагын үйл ажиллагаа	11
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	11
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	12
4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	15
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
5.1 Шилэн дансны мэдээлэл	16
5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	16
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
8. Аудитын илрүүлэлт	16
8.1 Залруулсан алдаа	16
8.2 Төлбөрийн акт	17
8.3 Албан шаардлага	17
8.4 Зөвлөмж	17
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
АХГ	Аудитын хоёрдугаар газар
БНМАУ	Бүгд найрамдах монгол ард улс
БХӨТ	Богино хугацаат өр төлбөр
ДЭХ	Дулааны эрчим хүч
ИТА	Инженер, техникийн ажилтан
НА	Нийцлийн аудит
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн татвар
ОСНААУГ	Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨА	Төрийн өмчийн аудит
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨХК	Төрийн өмчийн хувьцаат компани
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
УХӨТ	Урт хугацаат өр төлбөр
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭХЗХ	Эрчим хүчний зохицуулах хороо



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

УЛААНБААТАР ДУЛААНЫ
СҮЛЖЭЭ ТӨХК-ИЙН ЗАХИРАЛ
Г.БАЯРСАЙХАН ТАНАА

2022.03.15 № 07/539
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Улаанбаатар Дулааны Сүлжээ ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Улаанбаатар Дулааны Сүлжээ ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Улаанбаатар Дулааны Сүлжээ ТӨХК нь дулааны цахилгаан станцуудаас дулааны эрчим хүчийг худалдан авч, хэрэглэгчдэд борлуулсан орлогыг техникийн болон үйл ажиллагааны онцлогоос шалтгаалан тухайн сард нь бус дараа сард нь борлуулалтын орлогоор хүлээн зөвшөөрч нягтлан бодох бүртгэлд тайлагнадаг байсныг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлд нийцүүлэн залруулах бичилт хийсэн байна.

Бусад асуудал

Монгол улсын Засгийн газар Европын сэргээн босголт, хөгжлийн банктай хамтран ажиллах стратегийн баримт бичгийн хүрээнд тус банкны санхүүжилтээр Монгол улсад хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг тодорхойлсон 300.0 сая ам.долларын Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрт 2019 оны 04 дүгээр сард 2 тал гарын үсэг зурсан ба 2019 оны 09

дүгээр сард Засгийн газрын 356 дугаар тогтоолоор төслийн жагсаалтыг баталж, Монгол Улсын Их хурлаар баталсан байна.

Тус хэлэлцээрийн хүрээнд 2020-2023 онд “Улаанбаатар хотын дулаан хангамжийн төсөл” хэрэгжих бөгөөд 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр зээлийн гэрээ болон Төслийн гэрээнд 3 талын төлөөлөл гарын үсэг зурж баталгаажуулжээ.

Төслийн нийт санхүүжилт 16.6 сая ам.доллар бөгөөд үүнээс 10.0 сая ам.доллар нь зээл, 5.0 сая ам.доллар нь буцалтгүй тусламж бөгөөд техникийн хамтын ажиллагааны туслалцааны хүрээнд 1.6 сая долларыг Европын сэргээн босголт, хөгжлийн банкны Хувьцаа эзэмшигчдийн тусгай сан (SSF)-с санхүүжүүлэхээр байна.

Төслийн хүрээнд тайлант онд барилга угсралтыг ажлыг эхлүүлжээ.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Эрчим хүчний сайдын 2021 оны А/161 дугаар тушаалаар 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд нийт орлогыг 118,254.3 сая төгрөгөөр, нийт зардлыг 125,823.3 сая төгрөгөөр, 7,569.0 сая төгрөгийн алдагдалтай байхаар тодотгож баталсан байна.

Гүйцэтгэлээр 123,229.3 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 123,000.7 сая төгрөгийн зардал гарган, 3,675.7 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Хөрөнгө оруулалтын 67 арга хэмжээнд 8,152.5 сая төгрөгийг төлөвлөснөөс 52 ажилд өөрийн эх үүсвэрээс 7,929.0 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлэн, гүйцэтгэлийг 97.3 хувьтай тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	2,414,988,235.83	2,098,576,793.71
1.1.2	Дансны авлага	2,730,721,571.61	25,973,265,807.52
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	387,355,376.84	-
1.1.4	Бусад авлага	1,787,640,709.36	1,685,680,980.64
1.1.6	Бараа материал	755,298,556.74	773,643,857.22
1.1.7	Урьдчилж төлсөн зардал, тооцоо	290,749,538.02	25,837,451.91
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	8,366,753,988.40	30,557,004,891.00
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	221,234,512,018.77	225,892,084,384.64
1.2.2	Биет бус хөрөнгө	2,989,424,910.92	2,688,702,258.92
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	11,453,941,866.13	10,436,705,545.84
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	1,516,687,233.54	1,660,630,260.48
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	237,194,566,029.36	240,678,122,449.88
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	245,561,320,017.76	271,235,127,340.88
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	1,762,835,919.13	1,459,592,247.71
2.1.1.3	Татварын өр	-	4,075,617,593.56
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	1,288,450,256.48	594,377,245.89
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	92,992,776.35	222,276,086.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	3,144,278,951.96	6,351,863,173.16
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	17,128,200,515.07	15,623,391,012.07
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	3,063,284,955.06	2,934,605,653.66
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	20,191,485,470.13	18,557,996,665.73
2.2	Өр төлбөрийн нийт дүн	23,335,764,422.09	24,909,859,838.99
2.3	Эздийн өмч		
2.3.1	Төрийн өмч	187,466,284,809.35	208,731,008,677.41
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	18,361,736,665.58	17,962,229,372.48
2.3.9	Эздийн өмчийн бусад хэсэг	23,408,987,568.06	11,748,393,278.40
2.3.10	Хуримтлагдсан ашиг	(7,011,453,447.32)	7,883,636,173.70
2.3.11	Эздийн өмчийн дүн	222,225,555,595.67	246,325,267,501.99
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	245,561,320,017.76	271,235,127,340.88

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	109,316,988,054.28	122,458,378,535.30
2	Борлуулалтын өртөг	81,483,802,382.13	90,663,876,898.26
3	Нийт ашиг (алдагдал)	27,833,185,672.15	31,794,501,637.04
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүгийн орлого	142,721,224.80	8,896,219.56
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	1,271,104,479.63	762,064,177.95
9	Борлуулалт, маркетингийн зардал	42,392,557.18	82,147,272.39
10	Ерөнхий ба удирдлагын зардал	29,155,693,637.60	29,936,006,630.50
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	778,205,596.56	915,865,371.32

13	Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз (гарз)	115,875.55	(546.28)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(1,415,370,553.49)	(1,402,753,430.90)
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(2,144,535,092.70)	228,688,783.16
19	Орлогын татварын зардал	-	3,904,396,741.94
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(2,144,535,092.70)	(3,675,707,958.78)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(2,144,535,092.70)	(3,675,707,958.78)
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
23.3	Бусад олз (гарз)	-	-
24	Орлогын нийт дүн	(2,144,535,092.70)	(3,675,707,958.78)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	174,531,041,480.35	18,810,123,237.03	14,986,597,562.11	(5,321,322,384.83)	203,006,439,894.66
Залруулсан үлдэгдэл	174,531,041,480.35	18,810,123,237.03	14,986,597,562.11	(5,321,322,384.83)	203,006,439,894.66
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	21,357,783,148.06	-	21,357,783,148.06
Өмчид гарсан өөрчлөлт	12,935,243,329.00	-	(12,935,393,142.11)	(10,842,186.89)	(10,992,000.00)
Зарласан ногдол ашиг	-	-	-	(13,758,092.90)	(13,758,092.90)
Тайлан үеийн цэвэр ашиг алдагдал	-	-	-	(2,144,535,092.70)	(2,144,535,092.70)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	(448,386,571.45)	-	479,004,310.00	30,617,738.55
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	187,466,284,809.35	18,361,736,665.58	23,408,987,568.06	(7,011,453,447.32)	222,225,555,595.67
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	18,171,290,286.70	18,171,290,286.70
Залруулсан үлдэгдэл	187,466,284,809.35	18,361,736,665.58	23,408,987,568.06	11,159,836,839.38	240,396,845,882.37
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	9,604,129,578.40	-	9,604,129,578.40
Өмчид гарсан өөрчлөлт	21,264,723,868.06	-	(21,264,723,868.06)	-	-
Тайлан үеийн цэвэр ашиг алдагдал	-	-	-	(3,675,707,958.78)	(3,675,707,958.78)

Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	(399,507,293.10)	-	399,507,293.10	-
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	208,731,008,677.41	17,962,229,372.48	11,748,393,278.40	7,883,636,173.70	246,325,267,501.99

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

		/төгрөгөөр/	
Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн	122,934,156,460.54	132,256,507,390.99
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	122,780,230,076.78	132,112,559,600.43
1.1.6	Бусад мөнгөн орлого	153,926,383.76	143,947,790.56
1.2	Мөнгөн зарлагын дүн	(111,582,066,926.11)	(123,662,731,414.48)
1.2.1	Ажиллагчдад төлсөн мөнгө	9,785,402,734.00	9,405,661,712.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	3,162,431,954.27	3,209,550,489.78
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн мөнгө	1,055,073,639.00	977,434,072.20
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	2,011,533,947.45	1,794,465,362.63
1.2.7	Татварын байгууллагад төлсөн мөнгө	3,562,275,163.91	5,388,318,522.99
1.2.9	Бусад мөнгөн зарлага	92,005,349,487.48	102,887,301,254.88
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	11,352,089,534.43	8,593,775,976.51
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.2	Мөнгөн зарлагын дүн	(9,814,575,673.41)	(8,910,186,872.35)
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	7,883,129,790.00	7,008,837,179.00
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,931,445,883.41	1,901,349,693.35
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(9,814,575,673.41)	(8,910,186,872.35)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн	120,902.51	1,852.54
3.1.4	Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	120,902.51	1,852.54
3.2	Мөнгөн зарлагын дүн	(5,026.96)	(2,398.82)
3.2.5	Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	5,026.96	2,398.82
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	115,875.55	(546.28)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	1,537,629,736.57	(316,411,442.12)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	877,358,499.26	2,414,988,235.83
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,414,988,235.83	2,098,576,793.71

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт		Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны			
					Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Нийт орлого		сая.төг	110,730.9	118,254.3	123,229.3	4,975.0	104.2
	Үүнээс: Борлуулалтын орлого	Бичилт	сая.төг	109,317.0	117,571.1	122,458.4	4,887.3	104.2
		Цуглуулалт	сая.төг	109,947.8	118,171.8	120,123.6	10,175.8	101.6
	Борлуулалтын орлого цуглуулалтын хувь		%	100.6	100.5	98.1	2.4	97.6
	Үйл ажиллагааны бус орлого		сая.төг	1,413.9	683.2	771.0	87.8	112.9
2	Нийт зардал		сая.төг	112,875.5	125,823.3	123,000.7	2,822.6	97.8
	Үүнээс: Үйл ажиллагааны зардал		сая.төг	29,904.3	31,799.1	30,714.3	(1,084.8)	96.6
	Үүнээс: ДЭХ-ний зардал		сая.төг	81,483.8	92,554.9	90,663.9	(1,891.0)	98.0
	Үйл ажиллагааны бус зардал		сая.төг	1,487.3	1,469.2	1,622.5	153.3	110.4
3	Үйл ажиллагааны ашиг, алдагдал		сая.төг	(2,144.5)	(7,569.0)	228.7	7,797.7	133.1
4	Татварын дараах ашиг, алдагдал		сая.төг	(2,144.5)	-	(3,675.7)	(3,675.7)	-
5	Нийт авлага		сая.төг	25,372.4	24,717.7	27,776.3	3,058.6	112.4
	Үүнээс:	ДЭХ-ний	сая.төг	23,522.4	22,861.7	26,090.7	3,229.0	114.1
		Бусад	сая.төг	1,850.0	1,850.0	1,685.7	(164.3)	91.1
6	Нийт өглөг		сая.төг	23,335.7	23,348.5	24,909.9	1,561.4	106.7
	Үүнээс:	УХӨТ	сая.төг	20,191.5	18,642.9	18,588.0	(54.9)	99.7
		БХӨТ	сая.төг	3,144.2	4,705.6	6,351.9	1,646.3	135.0
7	Эргэлтийн хөрөнгө		сая.төг	8,366.8	-	30,557.0	30,557.0	-
8	Эргэлтийн бус хөрөнгө /Үндсэн хөрөнгө/		сая.төг	351,419.8	-	362,492.8	362,492.8	-
	Үүнээс: Үйлдвэрлэлийн		сая.төг	-	-	-	-	-
	Ерөнхий хэрэглээний		сая.төг	351,419.8	-	362,492.8	362,492.8	-
	Бусад		сая.төг	-	-	-	-	-
9	Нийт ажиллагсад		Тоо	390	393	385	(8)	98.0
10	Цалингийн сан		сая.төг	11,887.0	11,939.2	11,483.6	(455.6)	96.2
11	Дундаж цалин		төгрөг	2,539,960.	2,531,632	2,485,631	(46,001.0)	98.2
	Үүнээс: Удирдлага		төгрөг	5,123,044	5,369,052	5,382,388	13,336.0	100.2
	ИТА		төгрөг	3,142,727	3,139,350	3,114,955	(24,395.0)	99.2
	Ажилчид		төгрөг	2,053,924	2,033,236	1,962,106	(71,130.0)	96.5

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Улаанбаатар Дулааны Сүлжээ ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн нийт 3,024.2 сая төгрөгийн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал, аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад нягтлан бодох бүртгэл ба худалдан авах үйл ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 02 дугаар сарын 15-аас 2022 оны 03 дугаар сарын 15-ны хооронд “Бизкон Аудит” ХХК-ийн ахлах аудитор Б.Наранбат, аудитор О.Хишигмаа нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Ц.Болдбаатар, захирал Л.Отгонбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Улаанбаатар Дулааны Сүлжээ ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 01/141 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд Улаанбаатар Дулааны Сүлжээ ТӨХК-ийн засаглал, дотоод хяналтын систем, эрсдэлийг үнэлэх асуулгыг авсны үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үнэлж байна.

Тус компанид мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Улаанбаатар Дулааны Сүлжээ ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн А/62 дугаар тушаалаар шинэчлэн баталсан бөгөөд энэхүү бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд Улаанбаатар Дулааны Сүлжээ ТӨХК-ийн 2018-2019 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд ТӨБЗГ-аас, 2021 оны санхүүгийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт, их засвар, техник зохион байгуулалт, худалдан авах үйл ажиллагаанд Эрчим хүчний Яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас, 2020 он, 2021 оны эхний хагас жилийн санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд Сангийн Яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газраас тус тус хяналт, шалгалт хийгдсэн байна.

ТӨБЗГ-аас ирүүлсэн 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 107 дугаар тогтоолын дагуу хийх ажлын төлөвлөгөөг батлуулж, төлөвлөгөөний биелэлт 100 хувь, Эрчим хүчний Яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хийсэн хяналт, шалгалтын мөрөөр хэрэгжүүлэх зөвлөмжийн хэрэгжилт 100 хувь, Сангийн Яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газраас хийсэн хяналт, шалгалтын тайлан эцэслэгдээгүй, хяналтын шатандаа байна.

Дотоод хяналтын нэгжийн чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод хяналтын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод хяналтын мэргэжилтнээс шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Улаанбаатар Дулааны Сүлжээ ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 123,000.7 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 1,230.0 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Улаанбаатар Дулааны Сүлжээ ТӨХК-ийн зорилго нь найдвартай, үр ашигтай ажиллагааг хангаж хот, суурин газрын хөгжлийн тулгуур хүч нь болоход оршино.

Улаанбаатар Дулааны Сүлжээ ТӨХК-ийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Дулаан эрчим хүчийг түгээх, хангах шугам тоноглолын засвар үйлчилгээ хийх, найдвартай ажиллагааг хангах;
- Эрчим хүчний барилга, байгууламж барих;
- Дулаан түгээх;
- Дулааны эрчим хүчээр зохицуулалттай ба зохицуулалтгүй хангах.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд төрийн өмчит хувьцаат компани гэсэн статустай байна. Өмчийн 100.0 хувийг төр, үүнээс ТӨБЗГ 30.0 хувь, Эрчим хүчний яам 70.0 хувийг эзэмшиж байна.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Улаанбаатар Дулааны Сүлжээ ТӨХК нь БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1959 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 367 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын дулаацуулах байгууламжийн ашиглалт, засварыг хариуцах үүрэгтэй Дулааны шугам сүлжээний ашиглалтын газрыг байгуулснаар тус компани анх байгуулагдсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;” гэсэн заалттай нийцэж байна.

Компанийн удирдлага болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаас томилж байгаа нь Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7. “төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;” гэсэн заалттай нийцэж байна.

Улаанбаатар Дулааны Сүлжээ ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллыг сард 0.8 сая төгрөгөөр тогтоосон нь ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 12

дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7-д “цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна” гэсэн заалтай нийцэж байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна.

Энэ хүрээнд Компанийн тухай хуулийн дагуу компанийн ТУЗ нь 2021 онд цахимаар 9, танхимаар 1, ажлын шугамаар 1, нийт 11 удаа хуралдаж 37 тогтоол баталж, хэрэгжүүлэн ажилласан байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3-т заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтцийг ТУЗ-ийн 2021 оны 12 дугаар тогтоолоор баталж, 2021 онд шинээр бүтэц, орон тоо нэмээгүй бөгөөд 3 орон тоог одоогийн байдлаар царцаасан байна. Ажлын байр, албан тушаалын давхардлыг арилгах талаар судалгаа, мэдээлэл боловсруулж, ажлын уялдаа холбоо, чиг үүргийг оновчтой зохион байгуулж ажилласан байна. Цалингийн зардлын хувьд цалин хөлс нэмэгдүүлээгүй, цалингийн зардлыг тайлант онд 455.6 сая төгрөгөөр хэмнэжээ. Удирдлагын цалин хөлсийг компанид мөрдөгдөж буй журам, жишиг цалингийн дагуу тооцон олгодог ба зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгалын зардал гаргаагүй ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”;
- Хөдөлмөрийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/
- Хөдөлмөрийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай;
- Цахим гарын үсгийн тухай хууль;
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журам;
- ЭХЗХ-ны 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 33, 34, 35, 39, 56 тоот тогтоол;
- ЭХЗХ-ны 2021 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 14 тоот тогтоол;
- ЭХЗХ-ны 2021 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 479, 480, 481, 484 тоот тогтоол;
- ЭХЗХ-ны 2021 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 511 тоот тогтоол;
- ЭХЗХ-ны 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 561, 562, 563, 567 тоот тогтоол;
- ЭХЗХ-ны 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 679 тоот тогтоол;
- Улаанбаатар Дулааны Сүлжээ ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн А/60 дугаар тушаал “Ажиллагсдад сарын үйл ажиллагааны үр дүнгийн нэмэгдэл хөлс, цалинг олгох журам”;
- Улаанбаатар Дулааны Сүлжээ ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн А/62 дугаар тушаал “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн батлах тухай”.

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Улаанбаатар Дулааны Сүлжээ ТӨХК-ийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/сая төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	2,415.0	2,098.6	(316.4)
Авлага	4,905.8	27,659.0	22,573.2
Урьдчилгаа	290.7	25.8	(264.9)
Бараа материал	755.3	773.6	18.3
Үндсэн хөрөнгө	221,234.5	225,892.1	4,657.6
Биет бус хөрөнгө	2,989.4	2,688.7	(300.7)
Урт хугацаат хөрөнгө оруулалт	11,453.9	10,436.7	(1,017.2)
Хойшлогдсон татварын хөрөнгө	1,516.7	1,660.6	143.9
Нийт хөрөнгийн дүн	245,561.3	271,235.1	25,673.8
Богино хугацаат өглөг	3,144.3	6,351.9	3,207.6
Урт хугацаат өглөг	20,191.5	18,558.0	(1,633.5)
Эздийн өмч	222,225.5	246,325.2	24,099.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	245,561.3	271,235.1	25,673.8

Касс дахь бэлэн мөнгө 1.3 сая, арилжааны банкны харилцах дансанд 2,097.3 сая төгрөгийн мөнгөн хөрөнгө байна.

Тайлант онд дулааны эрчим хүч борлуулалтын үйл ажиллагааны хүрээнд үүссэн дулаан борлуулалтын авлага 23,242.5 сая төгрөгөөр нэмэгдсэн нь авлагын өсөлтөд голлон нөлөөлжээ.

Авлагын үлдэгдэлд хугацаандаа байгаа 27,170.3 сая төгрөгийн, хугацаа хэтэрсэн 488.6 сая төгрөгийн найдваргүй авлага байна. Найдваргүй авлагыг нөөцийн аргаар тооцдог байна. Тайлант онд 30.4 сая төгрөгийн найдваргүй авлагын нөөц байгуулж, Эрчим хүчний яамны 2021 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн 5/3137 тоот албан тоот, ТӨБЗГ-ын 2021 оны 09 дүгээр сарын 13-ны А-1/1462 тоот албан бичиг, ТУЗ-ийн 2021 оны 08 дугаар 12-ны 25 дугаар тогтоолыг үндэслэн 27.9 сая төгрөгийн найдваргүй авлагыг данснаас хассан байна.

Тайлант онд бэлтгэн нийлүүлэгчдэд дулааны эрчим хүчний төлбөрт 5,904.3 сая төгрөгийн урьдчилгаа шилжүүлсэн байна. Урьдчилгаа дансны эхний үлдэгдэлд бүртгэлтэй 2020 онд шилжүүлсэн 13.7 сая төгрөгийн Татварын ерөнхий газарт төлсөн тэмдэгтийн хураамж, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардал зэргийн үлдэгдэл байна. Урьдчилгаа данснаас тайлант онд шүүхээр шийдэгдсэн хэргүүдийн 4.6 сая төгрөгийг бусад борлуулалтын зардал дансанд шилжүүлэн бүртгэсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 773.6 сая төгрөг болж 18.3 сая төгрөгөөр өссөн нь сэлбэг хэрэгслийн үлдэгдэл 4.3 сая төгрөгөөр, хангамжийн материал үлдэгдэл 2.0 сая төгрөгөөр, бусад бараа материалын үлдэгдэл 12.0 сая төгрөгөөр өссөнөөс шалтгаалжээ. Тайлант онд худалдан авалтаар 1,269.3 сая төгрөгийн бараа материал нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө эргэлтийн хөрөнгөөс капиталжсан 186.4 сая, өөрийн хөрөнгөөр худалдан авсан 6,034.8 сая, нөөц хөрөнгөөс капиталжсан 995.5 сая, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 9,604.1 сая, Европын сэргээн босголтын банк, Дэлхийн банкны төслөөр 1,675.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө тус тус нэмэгдсэн байна.

ТӨБЗГ-ын 2021 оны А-1/684, 182, 334 дүгээр тогтоолын дагуу 4,718.9 сая төгрөгийн акталсан хөрөнгө, 164 дүгээр тогтоолоор балансаас баланст шилжүүлсэн 33.9 сая төгрөгийн хөрөнгийн дүнгээр хасагджээ.

Биет бус хөрөнгө 2,688.7 сая төгрөг болж 300.7 сая төгрөгөөр буурсан нь биет бус хөрөнгөд тооцсон хорогдлоос шалтгаалсан байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайланд бүртгэлтэй 1,078.2 сая төгрөгийн ажилчдын орон сууц нь ажиллагсдын нэр дээр өмчлөгчийн эрхийн гэрчилгээтэй байгаа нь санхүүгийн тайлангийн оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Дуусаагүй барилга дансны үлдэгдэл нь 2,273.9 сая төгрөг болж өмнөх оноос 1,994.8 сая төгрөгөөр өссөн нь Европын сэргээн босголт, хөгжлийн банкны болон Дэлхийн банкны төслийн хүрээнд хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээнээс шалтгаалжээ.

Урт хугацаат хөрөнгө оруулалт 10,436.7 сая төгрөг болж 1,107.2 сая төгрөгөөр буурсан нь Азийн хөгжлийн банкны Эрчим хүчний хэмнэлтийн төсөл, Дулааны үр ашгийн төслийн урт хугацаат зээлийн үндсэн төлбөрийн төлөлтөөс шалтгаалжээ.

Хойшлогдсон татварын хөрөнгө 1,660.6 сая төгрөг болж 143.9 сая төгрөгөөр өссөн нь үндсэн хөрөнгийн худалдан авалттай холбоотойгоор 368.8 сая төгрөгөөр өсөж, үндсэн хөрөнгийн НӨАТ-ын тайлант хугацааны хорогдуулал 60.6 сая төгрөг, өмнөх оны алдагдлыг шилжүүлэн тооцсоноос 164.3 сая төгрөг буурсан зэргээс шалтгаалсан байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд 1,459.6 сая төгрөгийн дансны өглөг, 4,075.6 сая төгрөгийн татварын өр, 594.4 сая төгрөгийн урьдчилж орсон орлого, 222.3 сая төгрөгийн бусад богино хугацаат өр төлбөр байна.

Урт хугацаат өр төлбөр дансанд Сангийн яам, Улаанбаатар Дулааны Сүлжээ ТӨХК-ийн хооронд 2006 оны 8 дугаар сарын 17-ны өдөр байгуулагдсан “Эрчим хүчний хэмнэлтийн төсөл”-ийн “1492 MON(SF)” дугаартай 26 тоот Дамжуулан зээлдүүлэх гэрээний үлдэгдэл 3,542.2 сая төгрөг, Сангийн яам, Улаанбаатар Дулааны Сүлжээ ТӨХК-ийн хооронд 2013 оны 5 дугаар сарын 29-ны өдөр байгуулсан “Дулааны үр ашгийн төсөл”-ийн “1548-MON(SF)” дугаартай 20 тоот зээлийн гэрээний үлдэгдэл 12,081.2 сая төгрөг, нийт 15,623.4 сая төгрөгийн урт хугацаат зээлийн үлдэгдэл байна. Урт хугацаат зээлийн эргэн төлөгдөх хугацаа нь 2032 онд дуусгавар болно.

Бусад урт хугацаат өр төлбөр дансанд ТӨБЗГ-ын 2019 оны 06 сарын 18-ний өдрийн 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.1-д заасны дагуу компанийн үндсэн хөрөнгөд бүртгэсэн хөрөнгийн хойшлогдсон орлого болох 2,934.6 сая төгрөгийн өр байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 246,325.2 сая төгрөг болж 24,099.7 сая төгрөгөөр өссөн нь төрийн өмч 21,264.7 сая төгрөгөөр, хуримтлагдсан ашиг 14,895.1 сая төгрөгөөр өссөн, эздийн өмчийн бусад хэсэг 11,660.6 сая төгрөгөөр, хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл 399.5 сая төгрөгөөр буурснаас шалтгаалжээ. Үүнд:

- Төрийн өмчийн дансны үлдэгдэл 208,731.0 сая төгрөг болж 21,264.4 сая төгрөгөөр өссөн нь Улаанбаатар Дулааны Сүлжээ ТӨХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 2021 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 06 тоот тогтоолоор “Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 21,264,723,868.06 /Хорин нэгэн тэрбум хоёр зуун жаран дөрвөн сая долоон зуун хорин гурван мянга найман зуун жаран найман төгрөг зургаан мөнгөн/ төгрөгийн хөрөнгийн дүнгээр өөрийн хөрөнгийн дүнг нэмэгдүүлэхийг гүйцэтгэх захирал Г.Баярсайханд зөвшөөрсүгэй.” гэсэн үндэслэлээр нэмэгдүүлж бүртгэсэн;
- Хувьцааны дансны үлдэгдэл 2020 онд 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 1,874,662,848 ширхэг хувьцаа байсан нь 2021 онд 2,087,310,086 ширхэг 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 208,731.0 сая төгрөг болж өссөн;
- Хөрөнгийн дахин үнэлгээний данс 17,962.2 сая төгрөг болж 399.5 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд акталсан хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл;
- Эздийн өмчийн бусад хэсэг дансны үлдэгдэл 11,748.4 сая төгрөг болж 11,660.6 сая төгрөгөөр буурсан нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө 21,264.7 сая төгрөгөөр буурч, ТӨБЗГ-ын 2021 оны 114, 277, 358, 489 дүгээр тогтоолуудын дагуу 9,604.1 сая төгрөгөөр өссөн зэргээс шалтгаалсан байна.

Шалгагдагч байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт үйл ажиллагааны зардлын хүлээн зөвшөөрөлт ба үнэлгээг аккрузал сууриар хүлээн зөвшөөрч тусгахаар заасан байна.

Санхүүгийн тайланд зардал, өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал гэж ангилсан байна. Тайлант оны борлуулалтын өртөг, үйл ажиллагааны болон үйл ажиллагааны бус зардал өмнөх онтой харьцуулахад 10,137.8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь борлуулсан бүтээгдэхүүний өртөг 9,180.1 сая төгрөгөөр, борлуулалт, маркетингийн зардал 39.7 сая төгрөгөөр, үйл ажиллагааны зардал 780.3 сая төгрөгөөр, үйл ажиллагааны бус зардал 137.7 сая төгрөгөөр өссөнөөс шалтгаалжээ.

Борлуулсан бүтээгдэхүүний өртөгт дулаан үйлдвэрлэгчдээс худалдан авсан дулааны эрчим хүчний үнийг тусгасан байна. НБББББ-т “Улаанбаатар Дулааны Сүлжээ ТӨХК-ийн хувьд борлуулсан бүтээгдэхүүний өртөг нь дулаан үйлдвэрлэгчдээс худалдан авсан дулааны эрчим хүч байна” гэж заасан нь СТОУС-тай нийцэж байна.

4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Улаанбаатар Дулааны Сүлжээ ТӨХК-ийн үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Эрчим хүчний сайдын 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/17 дугаар тушаалаар Улаанбаатар Дулааны Сүлжээ ТӨХК-ийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 114,896.4 сая төгрөгөөр, нийт зардлыг 119,279.5 сая төгрөгөөр, 4,383.1 сая төгрөгийн алдагдалтай байхаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 8,152.5 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Эрчим хүчний сайдын 2021 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн А/161 дугаар тушаалаар нийт орлогыг 118,254.3 сая төгрөгөөр, нийт зардлыг 125,823.3 сая төгрөгөөр, 7,569.0 сая төгрөгийн алдагдалтай байхаар тодотгосон байна.

Гүйцэтгэлээр 123,229.3 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 123,000.7 сая төгрөгийн зардал гарган, 228.6 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай, 3,675.7 сая төгрөгийн татварын дараах алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 123,229.3 сая төгрөг болж төлөвлөснөөс 4,975.0 сая төгрөг буюу 4.2 хувиар давсан нь тайлант онд 1Гкал-ын үнэ төлөвлөгөөнөөс 1,015.5 төгрөгөөр буюу 6.0 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 123,000.7 сая төгрөг болж, төлөвлөснөөс 2,822.6 сая төгрөг буюу 2.2 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь үйл ажиллагааны зардлыг 1,084.8 сая төгрөгөөр, дулааны эрчим хүчний зардлыг 1,891.0 сая төгрөгөөр тус тус дутуу, үйл ажиллагааны бус зардлыг 153.3 сая төгрөгөөр илүү зарцуулсан нь гол нөлөө үзүүлсэн байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 67 нэр төрлийн 52 ажилд өөрийн эх үүсвэрээс 7,929.0 сая төгрөгийг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд цэвэр алдагдал 3,675.7 сая төгрөг болж, төлөвлөснөөс 3,893.3 сая төгрөгөөр буурсан нь өмнөх оны 12 дугаар сарын борлуулалтын орлогыг тайлант оны 1 дүгээр сард тооцоноос шалтгаалсан байна.

Тайлант онд ТӨБЗГ-т ногдол ашгийн орлого төвлөрүүлээгүй бөгөөд түрээсийн орлогын 40.0 хувь буюу 7,607.2 сая төгрөгийг төвлөрүүлжээ.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Улаанбаатар Дулааны Сүлжээ ТӨХК нь тайлант онд нийт 170 мэдээллийг Шилэн дансны цахим системд хугацаанд нь мэдээлсэн байна.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Худалдан авах ажиллагаатай холбоотойгоор Улаанбаатар Дулааны Сүлжээ ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын 2021 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн “Тендерийн үнэлгээний хороо байгуулах тухай” А/57 тоот тушаалд нэр нь ороогүй ажилтан 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн Үнэлгээний хорооны “Өвлийн ажлын хувцас”, “Өвлийн ажлын гутал”, нийлүүлэх тендерийн бичиг баримтыг боловсруулах, тендер шалгаруулалтыг зохион байгуулах ажилд оролцсон нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 47 дугаар зүйл. 47.9. “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан журмаар зохицуулна.” гэсэн заалттай нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар 3,943.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 1,954.5 сая төгрөгийг алдааг залруулж, 868.6 сая төгрөгийн зөрчлийг арилгасан, 1,120.7 сая төгрөгийн алдаа, зөрчил арилаагүй тул жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлтэд тусгасан.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 68.9 сая төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгснөөс 98.0 хувийн биелэлттэй байна.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар эзэмшлийн бус үндсэн хөрөнгийг шийдвэрлэсэн байдал болон найдваргүй авлагын зардлын тооцооллыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 3,024.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 1,901.5 сая төгрөгийн 3 алдааг залруулж, 2.0 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 0.6 сая төгрөгийн алдаа, зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 1,120.1 сая төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өглөө.

Залруулагдаагүй 1,122.7 сая төгрөгийн алдаа, зөрчил нь тогтоосон 1,230.0 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Зөрчилгүй” дүгнэлт өглөө.

8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 1,901.5 сая төгрөгийн 3 алдааг залрууллаа. Үүнд:

- 2021 оны 1 дүгээр сард залруулах бичилт хийхдээ Борлуулалт, эдийн засгийн хэлтсээс гаргаж өгсөн дүнгийн дагуу данс тус бүрээс залруулах бичилт хийлгүйгээр

хялбарчлах үүднээс 51100 дугаартай дансанд залруулах бичилтийг хуримтлуулан бүртгэсэн.

- УБДС ТӨХК нь 2020 оны 12 дугаар сарын борлуулалтын орлогыг 2021 оны 01-р дүгээр сарын борлуулалтын орлогоор хүлээн зөвшөөрөхдөө залруулга хийгдсэн дүнд ногдох 1,897.7 сая төгрөгийн ААНОАТ-ыг тооцож төсөвт төлөхөөр тусган тайлагнаагүй.
- Тайлант оны цайны газрын түрээсийн 8, 9, 10, 11 сарын түрээсийн орлого болох 3.8 сая төгрөгийг бусад орлого дансанд хуримтлуулан бүртгэж тайлагнасан.

8.2 Төлбөрийн акт

Тайлант онд "Хөдөлмөрийн хүндэт" медалиар шагнагдсанд хүндэтгэл үзүүлэх, оны шилдэг ажилтнуудад батламж, цом гардуулах зэрэгт нийт 2.0 сая төгрөгийн шагнал, урамшууллын зардал гаргасан нь Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17-ны 43 дугаар тогтоол 1.3. "төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх," гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

8.3 Албан шаардлага

1.Дансны авлага болон урьдчилж орсон орлого дансны үлдэгдлээс 5 харилцагчийн 0.6 сая төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн акт үйлдэж баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйл.14.4." Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.2. бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага; 14.4.3. бүх өр төлбөр" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх.

2.Тендерийн үнэлгээний хороо байгуулах тухай тушаалд нэр нь ороогүй ажилтан тендерийн бичиг баримтыг боловсруулах, тендер шалгаруулалтыг зохион байгуулах ажилд оролцсон. Энэ нь "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 47 дугаар зүйл 47.2.Үнэлгээний хороо байнгын бус ажиллагаатай байх бөгөөд дор дурдсан чиг үүрэгтэй байна: 47.2.1.техникийн тодорхойлолт бэлтгэх, тендерийн урилга, тендерийн баримт бичгийг боловсруулах, тендер хүлээн авах, тендер нээх ажиллагааг холбогдох зааврын дагуу гүйцэтгэх; 47.2.2.тендерийг хянан үзэх, үнэлэх, үнэлгээний дүгнэлт гаргах, гэрээ байгуулах эрх олгох шийдвэрийг захиалагчид өгөх. Уг шийдвэрийг энэ хуулийн 46.2-т заасан захиалагчийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан үндэслэлгүйгээр өөрчлөхийг хориглоно." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх.

8.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлд Ажилчдын орон сууц гэсэн дансанд тус компанийн эзэмшлийн бус 2007-2015 онд худалдан авсан 1,078.2 сая төгрөгийн 28 ш орон сууцыг хуримтлуулан бүртгэж тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн

20 дугаар зүйл. 20.2.3. “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;” гэсэнтэй нийцээгүй, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Тухайн компанийн эзэмшлийн бус хөрөнгийг ТӨБЗГ болон ТУЗ-д данс бүртгэлээс хасах санал оруулж шийдвэрлүүлэх.

2. Найдваргүй авлагын зардалтай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Санхүүгийн тайланд найдваргүй авлагын зардлыг 30.4 сая төгрөг буюу 41.9 сая төгрөгөөр дутуу тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл. 20.2.3. “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэнтэй нийцээгүй, тодруулга ба толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Найдваргүй авлагын нөөцийг тооцоолохдоо хэрэглэгч болон бусад холбогдогч талуудтай хийсэн гэрээ хэлцэл, баримт бичигт заасан авлага барагдуулах хугацааг үндэслэн авлагын үлдэгдэлд насжилтын шинжилгээг санхүүгийн программ дээр хийн, нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайланд тусган тайлагнаж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Улаанбаатар Дулааны Сүлжээ ТӨХК-ийн 2021 оны
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Залруулга		Акт		Үүнээс Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж			
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Санхүүгийн тайлангийн асуудлаар																		
1	УБДулааны сүлжээ ТӨХК	АХГ-2022/97/НА-СТА-ТӨА	2021 оны 1 дүгээр сард залруулах бичилт хийхдээ Борлуулалт, эдийн засгийн хэлтсээс гаргаж өгсөн дүнгийн дагуу данс тус бүрээс залруулах бичилт хийлгүйгээр хялбарчлах үүднээс 51100 дугаартай дансанд залруулах бичилтийг хуримтлуулан бүртгэсэн байна.	Данс бүрээр залруулга хийлгэв.	1	-	1	-										
2	УБДулааны сүлжээ ТӨХК	АХГ-2022/97/НА-СТА-ТӨА	Санхүүгийн тайланд найдваргүй авлагын зардлыг 30,409.4 мянган төгрөг буюу 41,948.3 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна.	Найдваргүй авлагын нөөцийг үнэн зөв тооцож, тайлагнаж байх зөвлөмж өгөв.	1	41,948.3									1	41,948.3		
3	УБДулааны сүлжээ ТӨХК	АХГ-2022/97/НА-СТА-ТӨА	2021 оны 12 дугаар сарын 31-нээр Дансны авлага болон урьдчилж орсон орлого дансны үлдэгдлээс 5 харилцагчийн үлдэгдлийг тооцоо нийлсэн акт үйлдэж баталгаажуулаагүй байна.	Авлага, өглөгийн үлдэгдлийг харилцагч байгууллагатай тооцоо нийлж, санхүүгийн тайланд тусгах албан шаардлага хүргүүлэв.	1	582.4					1	582.4						
4	УБДулааны сүлжээ ТӨХК	АХГ-2022/97/НА-СТА-ТӨА	Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлд тус компанийн эзэмшлийн бус 2007-2015 онд худалдан авсан 28 ш орон сууцыг хуримтлуулан бүртгэсэн байна.	Тухайн компанийн эзэмшлийн бус хөрөнгийг ТӨБЗГ болон ТУЗ-д данс бүртгэлээс хасах санал оруулж шийдвэрлүүлэх талаар зөвлөмж өгөв.	1	1,078,175.9									1	1,078,175.9		
5	УБДулааны сүлжээ ТӨХК	АХГ-2022/97/НА-СТА-ТӨА	2020 оны 12 дугаар сарын борлуулалтын орлогыг 2021 оны 01-р дүгээр сарын борлуулалтын орлогоор хүлээн зөвшөөрөхдөө	ААНОАТ-ыг тооцож төсөвт төлөхөөр залруулав.	1	1,897,716.5	1	1,897,716.5										

			ААНОАТ-ыг тооцож төсөвт төлөхөөр тусган тайлагнаагүй байна.														
6	УБДулааны сүлжээ ТӨХК	АХГ-2022/97/НА-СТА-ТӨА	Тайлант оны цайны газрын түрээсийн 8, 9, 10, 11 сарын түрээсийн орлогыг бусад орлого дансанд хуримтлуулан бүртгэж тайлагнасан байна.	Орлогын дансанд залруулга хийлгэв.	1	3,829.9	1	3,829.9									
7	УБДулааны сүлжээ ТӨХК	АХГ-2022/97/НА-СТА-ТӨА	Тайлант онд УБДС ТӨХК нь нийт 2,002.0 мянган төгрөгийн шагнал урамшууллын зардал тайлагнасан байна.	Улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.	1	2,002.0			1	2,002.0							
ДҮН					7	3,024,255.0	3	1,901,546.4	1	2,002.0	1	582.4				2	1,120,124.2
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал																	
1	УБДулааны сүлжээ ТӨХК	АХГ-2022/97/НА-СТА-ТӨА	Тендерийн үнэлгээний хороо байгуулах тухай тушаалд нэр нь ороогүй этгээд тендерийн бичиг баримтыг боловсруулах, тендер шалгаруулалтыг зохион байгуулах ажилд оролцсон.	Худалдан авах үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулах талаар албан шаардлага хүргүүлэв.	1	-					1	-					
ДҮН					1						1	-					
НИЙТ ДҮН					8	3,024,255.0	3	1,901,546.4	1	2,002.0	2	582.4				2	1,120,124.2



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 03 дугаар сарын 15

№ 347/А0150053
АКТ-2022/97/НА-СТА-ТӨА

Улаанбаатар хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу гүйцэтгэсэн Улаанбаатар Дулааны Сүлжээ ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд Улаанбаатар Дулааны Сүлжээ ТӨХК-ийн ажилтанд хүндэтгэл үзүүлэх, оны сайчуудад батламж, цом гардуулах зэрэг зардалд нийт 2,002,000.00 төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.3. "Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь үялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Шагнал, урамшуулал, хүндэтгэл үзүүлэх зэрэгт зарцуулсан 2,002,000.00 /хоёр сая хоёр мянган/ төгрөгийг холбогдох албан тушаалтнаар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банк дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Улаанбаатар Дулааны Сүлжээ ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Г.Баярсайхан, Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч Л.Баярсайхан нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР
БИЗКОН АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.ХОСЖАРГАЛ
Л.ОТГОНБАЯР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-261330

\\10.10.10.20\Bichig_Khereg\Akt\2022\0315 Auditin 4 Gazar-2.Docx

001030199



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15

№ 340/АУИС 0055
АХГ - 2022/197/НА - СТА - ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу гүйцэтгэсэн Улаанбаатар Дулааны Сүлжээ ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд ороогүй ажилтнаар тендерийн бичиг баримтыг боловсруулах, тендер шалгаруулалтыг зохион байгуулах ажилд оролцуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.9 “Үнэлгээний хороо гэж энэ хуульд заасан журмын дагуу тендер шалгаруулалтыг зохион байгуулах зорилгоор захиалагчийн байгуулсан ажлын хэсгийг”, 47 дугаар зүйл 47.2 “Үнэлгээний хороо байнгын бус ажиллагаатай байх бөгөөд дор дурдсан чиг үүрэгтэй байна: 47.2.1.техникийн тодорхойлолт бэлтгэх, тендерийн урилга, тендерийн баримт бичгийг боловсруулах, тендер хүлээн авах, тендер нээх ажиллагааг холбогдох зааврын дагуу гүйцэтгэх; 47.2.2.тендерийг хянан үзэх, үнэлэх, үнэлгээний дүгнэлт гаргах, гэрээ байгуулах эрх олгох шийдвэрийг захиалагчид өгөх. Уг шийдвэрийг энэ хуулийн 46.2-т заасан захиалагчийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан үндэслэлгүйгээр өөрчлөхийг хориглоно” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”. Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Холбогдох хууль тогтоомжид зааснаар шаардлага хангасан Үнэлгээний хорооны гишүүдээр тендерийн баримт бичгийг боловсруулах, тендер шалгаруулалтын ажлыг зохион байгуулж ажиллах, зөрчлийг арилган биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтаг гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллахыг Улаанбаатар Дулааны Сүлжээ ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Г.Баярсайхан, Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч Л.Баярсайхан нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
БИЗКОН АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Л.ОТГОНБЯЯР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Kherig\Alban Shaardloga\2022\03\5 Auditin 2 Gazar-20.Docx

00108C0995



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15

№ 341/АД150055

Улаанбаатар хот

АХТ-2022/97/НА-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу гүйцэтгэсэн Улаанбаатар Дулааны Сүлжээ ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Дансны авлага болон урьдчилж орсон орлогын үлдэгдлээс 5 харилцагчийн 582,398.00 төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн акт үйлдэж баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.”, 20 дугаар зүйлийн 20.2 “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: ... 20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;...” гэсэн заасныг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Авлага, өглөгийн үлдэгдлийг харилцагч байгууллагатай тооцоо нийлж, санхүүгийн тайланд тусгаж, зөрчлийг арилган биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллахыг Улаанбаатар Дулааны Сүлжээ ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Г.Баярсайхан, Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч Л.Баярсайхан нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
БИЗКОН АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Л.ОТГОНБАЯР



